

Т.Сараннэмэх
Нийслэлийн Боловсролын газрын багшийн хөгжил
насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтэн

ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ


Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу Ерөнхий боловсролын сургуулийн гадаад хэлний сургалтын агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт хэлэхүйн үйл ажиллагааны дөрвөн үндсэн чиглэлд тулгуурласан гадаад хэлний боловсролын айн агуулга багтана. Үүнд аман харилцааны (сонсох, ярих), бичгийн харилцааны (унших, бичих) үйл ажиллагааны мэдлэг, чадварыг тодорхойлсон болно.

Англи хэл, орос хэлний сургалтын хөтөлбөр нь гадаад хэлний боловсролын стандартад нийцүүлсэн тодорхой зорилго, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ бүхий үйл ажиллагааны тогтолцоог илэрхийлсэн удирдамжийн баримт бичиг юм.

НЭГ. Гадаад хэлний хөтөлбөрийн зорилго


- **Бага боловсролын түвшинд** Англи хэлийг 5-р ангид суралцагч бүр тодорхой сэдвээр санаа бодлоо энгийн хэлбэрээр илэрхийлэх, харилцах хүрээнд Европын холбооны нэгдсэн хүрээний англи хэлний Low A1 түвшинг баримжаалан суралцагчийн хүрвэл зохих үр дүнг тодорхойлон хэрэгжүүлж байна.
- **Суурь боловсролын түвшинд** хоёр гадаад хэлийг (англи хэл, орос хэл) судлахаар сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд Англи хэлийг 6-9 ангид суралцагч бүр эзэмшсэн мэдлэг, чадвараа ахиулан, судлах хам сэдвийн өргөтгөсөн хүрээнд харилцах, өөрийгөө илэрхийлэх, англи хэлийг хэрэглэх чадвар эзэмшихэд хөтөлбөр чиглэх бөгөөд Европын холбооны нэгдсэн хүрээний англи хэлний Low A1-Low A2 түвшинг баримжаалан суралцагчийн хүрвэл зохих үр дүнг тодорхойлон хэрэгжүүлж байна.
- **Бүрэн дунд боловсролын түвшинд** Сурагч нь нийгэм соёл, шинжлэх ухаан, ахуй амьдралын хүрээнд гадаад хэлний мэдлэгээ бүтээлчээр хэрэглэх, бие даан бүтээлчээр хэрэглэх
- Орос хэл - ТРКИ стандартын суурь хэсгийн элементар түвшин нь манай улсын 7-9 ангийн орос хэлний цагтай тохирч байгаа, Орос хэлийг гадаад хүнд заах

Европын Зөвлөлөөр батлагдсан ТРКИ буюу /TORFL - Test of Russian as a Foreign Language»/ стандартын А1 түвшинтэй уялдсан.



Гадаад хэлний сургалтын агуулгыг хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Сургалтын хөтөлбөртөө зорилгоо зөв тодорхойлж, түүн дээрээ тулгуурлан зорилтоо үйл ажиллагаагаар гүйцэтгэж, үр дүнгээ тооцох нь зүйтэй.



Гадаад хэлний сургалтын агуулгаар суралцагчид аман (сонсох, ярих) болон бичгийн (унших, бичих) харилцааны чадвар эзэмшинэ. Тухайлбал:

Харилцааны хэлбэр	Хүртэх	Бүтээлч
Аман харилцаа	сонсох	ярих

Гадаад хэлний агуулгыг эзэмшүүлэхдээ нэгэн зэрэг ярих, бичих мэдлэг, чадвартай болно гэж үзэж болохгүй бөгөөд хэзээ ч нэг сурагчийг нөгөөтэй нь харьцуулж болохгүй. Бага ангийн сурагчдад Хүүхэд бүр харилцан адилгүй чадвартай, хэл сурахдаа хурдан удаан янз бүр байж болдог. Гадаад хэлийг аль болох дэвтэр, ном, харандаа, шугамаас хол байлгаж, сонирхолтой, хөгжилтэй, идэвхтэй аргаар заах хэрэгтэй. Дүрэм заах гэж яарах хэрэггүй, тухайн хэлээр ярих бүх боломжоор хангаж өгөх нь зүйтэй.

Суралцагчид бүтээсэн мэдлэгээ агуулгын хүрээнд тусгасан ахуй амьдрал, нийгэм соёлын хам сэдвийн дагуу хэрэглэж суралцана.

Суралцагчид хэлэхүйн үндсэн чадвар эзэмшихийн зэрэгцээ нийгэм-соёлын чадамжтай болно.

Суралцагчдын сурах үйл явцыг хөгжүүлнэ.

Суралцагчдад тухайн хэлээр ярихад суралцах таатай орчин бүрдүүлэхийн тулд тэдгээрийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнтэй байх хэрэгтэй.

ХОЁР: Гадаад хэлийг эзэмшүүлж байгаа багш нарын арга зүйн өөрчлөлтийг хэрхэн хийх вэ?

Арга зүйн дараах зарчмыг баримтлах нь зүйтэй. Үүнд:

- ✓ Бодит байх. Тухайн хэлийг сурах орчинг бүрдүүлэх нь шинэ мэдлэгийг хурдан эзэмшихэд нөлөөлнө.
- ✓ Сонирхолтой байх. Хэлний сонирхолыг төрүүлэх нь багшийн гол үүрэг юм. Сонирхолгүй бол хүүхэд судлах хэлээ уйтгартай, төвөгтэй, хэцүү гэсэн хэвшмэл ойлголттой болдог.
- ✓ Дараалалтай байх. Дүрэм, дадлага, уншилт. Гэхдээ дүрмэнд хэт их анхаарах хэрэггүй. Тэгвэл сурагчид залхдаг.
- ✓ Тоглоомын хэлбэртэй байх. Хүүхдийн таних мэдэх үйл ажиллагааг хөгжүүлэх гол хэрэгсэл нь тоглоом.
- ✓ Өөртөө итгэх итгэлийг бий болгох. Эергээр харилцах болон сэдэл тэмүүлэлийг өдөөх

Багш нарын сургалтад ашигладаг түгээмэл аргууд:



Эдгээр аргуудыг сургалтад үр дүнтэй ашиглах нь чухал. Үүний тулд:

1. Сурагчдад тухайн хэлийг сурах сэдэл, хүсэл тэмүүллийг төрүүлэх
2. Хэл сурах, эзэмших үйл явцыг тухайн сурагчдын хувьд баяр баясгалан байх
3. Сургалтыг зохион байгуулахдаа интерактив орчныг бүрдүүлэх
4. Суралцагч төвтөй арга зүйг хэрэглэхэд анхаарах
5. Бага боловсролын түвшин буюу 5-р ангид сонсох, ярих чадварыг түлхүү оруулах, харааны ой, нүдлэх чадварыг хөгжүүлэхэд анхаарах
6. Суурь, бүрэн дунд боловсролын түвшинд хэлэхүйн үйл ажиллагааны 4 чадвар, сурах арга барилыг хөгжүүлэхэд анхаарах

Гадаад хэлийг эзэмшүүлэх 5 гол арга:




Хялбар уншиж, тоолж сурах /Зайцевийн арга/

- үе буюу үсэг бичсэн квадрат
- үе буюу үсэг бичсэн таблиц ашиглах



Тоглоомын арга

- хөгжүүлэх
- хүмүүжүүлэх зорилготой



Домино

- хоорондоо холбоотой үгүүд
- үгийн сүлжээ
- лото
- толь бичиг ашиглах



Төслийн аргачлал

- тодорхой зорилготой
- тодорхой сэдэв сонгож, төсөл бичих



Хамран ажиллах

- дүрэм сурахын тулд тоглох
- зурах

Гадаад хэлний багш нар сурагчдад гэрийн даалгаврыг хамгийн оновчтой өгч, бие даан сурах тэмүүллийг нь хөгжүүлж байх хэрэгтэй.

